



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/164/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 260512 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал : С.Тунгалаг Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.СҮХБААТАР
ТАНАА

2025.02.25 № 07/759
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаанбаатар хот дахь гаалийн газар нь Нэг цэгийн үйлчилгээний төв байрны 1 дүгээр давхрын засвар, 7 дугаар давхрын хурлын заалны засварын ажилд 553,070.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 790 дүгээр тогтоолоор 7,753,435.5 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох 61 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 3,031,452.1 мянган төгрөгөөр тогтоосныг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудал

Гаалийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	390,425,669.87	463,365,953.61
33	АВЛАГА	-	861,786.26
33500	Бусад авлага	-	861,786.26
3351	Байгууллагаас авах авлага	-	861,786.26
34	УРЬДЧИЛГАА	-	3,668,620.00
34600	Урьдчилж төлсөн зардал	-	3,668,620.00
35	БАРАА МАТЕРИАЛ	390,425,669.87	458,835,547.35
35300	Бэлэн бүтээгдэхүүн	252,099,363.63	293,389,078.63
35400	Хангамжийн материал	138,326,306.24	165,446,468.72
35410	Бичиг хэргийн материал	10,231,605.00	6,825,575.00
35420	Аж ахуйн материал	54,482,923.32	62,049,715.80
35440	Түлш,шатах тослох материал	2,956,500.00	5,396,500.00
35470	Бусад хангамжийн материал	70,655,277.92	91,174,677.92
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,845,178,874.25	9,064,402,811.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,845,178,874.25	9,064,402,811.45
39200	Биет хөрөнгө	4,712,660,451.25	8,930,094,388.45
39201	Барилга,байгууламж,орон сууц	5,479,450,911.00	6,674,688,581.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,057,152,561.84	1,168,667,369.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,612,170.00	46,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	96,562,170.00	-
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	7,917,429,624.65	3,494,054,481.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	7,681,676,420.01	360,876,133.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	419,951,521.31	281,808,252.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	370,059,290.18	38,380,090.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	17,333,333.68	19,333,333.72
39300	Биет бус хөрөнгө	132,518,423.00	134,308,423.00
39301	Программ хангамж	4,630,000.00	2,890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,530,000.00	-
39303	Бусад биет бус хөрөнгө	131,418,423.00	131,418,423.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,235,604,544.12	9,527,768,765.06
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	37,257,130.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	37,257,130.70
41300	Өглөг	-	37,257,130.70
41360	Бусад өглөг	-	37,257,130.70
41361	Байгууллагад өгөх өглөг	-	37,257,130.70
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	5,235,604,544.12	9,490,511,634.36
51	Засгийн газрын хувь оролцоо	6,849,976,358.38	6,849,976,358.38
51101	Засгийн газрын оруулсан капитал	6,849,976,358.38	6,849,976,358.38
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,615,822,037.11)	2,639,085,053.13
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,615,822,037.11)	(1,615,822,037.11)
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,254,907,090.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,450,222.85	1,450,222.85
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,235,604,544.12	9,527,768,765.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,285,424,372.00	14,254,376,366.99
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,054,672.00	3,912,498,522.99
120	Нийтлэг татварын бус орлого	300,054,672.00	3,912,498,522.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	220,844,202.00	3,904,235,752.99
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	-	40,625,184.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	220,844,202.00	3,863,610,568.99
120005	Түрээсийн орлого	79,175,470.00	7,912,770.00
120009	Бусад орлого	35,000.00	350,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,985,369,700.00	10,341,877,844.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,985,369,700.00	10,341,877,844.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,985,369,700.00	10,341,877,844.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,285,848,806.99	9,999,304,276.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,285,848,806.99	9,999,304,276.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,330,664,031.14	9,075,636,862.56
2101	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	6,729,258,058.48	8,533,033,214.97
21010	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	5,975,488,722.87	7,581,050,248.44
210101	Үндсэн цалин	4,791,282,501.00	3,703,294,149.27
210102	Нэмэгдэл	5,754,162.13	1,874,586,200.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	421,736,000.00	1,101,706,000.00
210104	Урамшуулал	756,716,059.74	901,463,898.64
21020	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	753,769,335.61	951,982,966.53
210201	Тэтгэврийн даатгал	516,211,037.35	650,136,170.43
210202	Тэтгэмжийн даатгал	59,592,513.99	76,406,155.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,674,010.95	39,687,985.74
210204	Ажилгүйдлийн даатгал	11,844,706.75	37,150,531.20
210205	Эрүүл мэндийн даатгал	118,447,066.57	148,602,123.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,203,886.67	75,087,819.28
210301	Гэрэл, цахилгаан	48,986,681.06	47,954,901.66
210302	Түлш, халаалт	17,071,555.61	17,089,973.79
210303	Цэвэр, бохир ус	7,145,650.00	10,042,943.83
2104	Хангамж, бараа материалын зардал	75,430,707.20	58,538,350.00
210401	Бичиг хэрэг	30,279,910.00	33,891,820.00
210402	Тээвэр, шатахуун	28,465,900.00	13,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,485,107.00	3,008,116.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,602,000.00	1,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,597,790.20	6,808,414.00
2105	Нормативт зардал	2,170,898.69	114,689.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,170,898.69	114,689.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,338,167.70	64,493,543.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	570,300.00	280,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	11,768,980.00	-
210604	Урсгал засвар	28,998,887.70	64,213,043.00
2107	Томилолт, зочны зардал	7,171,000.00	-
210702	Дотоод албан томилолт	7,171,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,839,126.00	100,070,257.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,182,206.00	34,925,146.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,817,590.00	7,567,740.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	66,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	57,751,330.00	52,511,371.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	286,252,186.40	244,298,988.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	286,252,186.40	244,298,988.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	955,184,775.85	923,667,414.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	288,182,000.00	319,545,344.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	319,545,344.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	288,182,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	635,332,587.85	604,122,070.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	635,332,587.85	604,122,070.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,670,188.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,670,188.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(424,434.99)	4,255,072,090.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,336,090.00	165,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	21,336,090.00	165,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(21,760,524.99)	4,254,907,090.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,064,580,170.00	10,349,826,949.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,210,470.00	7,949,105.00
120	Нийтлэг татварын бус орлого	79,210,470.00	7,949,105.00
120005	Түрээсийн орлого	79,175,470.00	7,912,770.00
120009	Бусад орлого	35,000.00	36,335.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,985,369,700.00	10,341,877,844.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,985,369,700.00	10,341,877,844.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,985,369,700.00	10,341,877,844.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,013,359,770.00	9,787,171,722.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,013,359,770.00	9,787,171,722.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,058,174,994.15	8,863,504,308.51
2101	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	6,729,258,058.48	8,533,895,001.23
21010	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	5,925,110,558.48	7,425,367,201.23
210101	Үндсэн цалин	2,646,424,859.40	2,743,270,872.75
210102	Нэмэгдэл	1,919,326,399.08	2,400,795,438.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	519,059,300.00	1,320,907,200.00
210104	Урамшуулал	840,300,000.00	960,393,689.75
21020	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	804,147,500.00	1,108,527,800.00
210201	Тэтгэврийн даатгал	597,712,300.00	726,574,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	49,108,800.00	134,207,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,287,000.00	65,666,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,821,800.00	36,416,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	108,217,600.00	145,664,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,158,186.67	74,931,619.28
210301	Гэрэл, цахилгаан	48,986,681.06	47,954,901.66
210302	Түлш, халаалт	16,433,170.61	16,933,773.79
210303	Цэвэр, бохир ус	7,738,335.00	10,042,943.83
2104	Хангамж, бараа материалын зардал	80,133,443.00	60,510,102.00
210401	Бичиг хэрэг	35,420,850.00	29,385,290.00
210402	Тээвэр, шатахуун	27,000,000.00	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,485,107.00	3,008,116.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,602,000.00	1,950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,625,486.00	11,166,696.00
2105	Нормативт зардал	14,356,090.00	3,285,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,410,090.00	3,285,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,946,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,391,440.00	94,278,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,600,590.00	9,815,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,310,000.00	-
210604	Урсгал засвар	43,480,850.00	84,462,810.00
2107	Томилолт, зочны зардал	7,171,000.00	-
210702	Дотоод албан томилолт	7,171,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,706,776.00	96,604,476.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,940,780.00	61,765,635.00

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,557,090.00	11,005,860.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,500.00	230,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,763,200.00	6,075,000.00
210807	Газрын төлбөр	297,206.00	461,481.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,800,000.00	12,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	955,184,775.85	923,667,414.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	288,182,000.00	319,545,344.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	319,545,344.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	288,182,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	635,332,587.85	604,122,070.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	635,332,587.85	604,122,070.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,670,188.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,670,188.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	51,220,400.00	562,655,226.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	51,220,400.00	562,655,226.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,220,400.00	562,655,226.30
2200	Дотоод эх үүсвэрээр	51,220,400.00	562,655,226.30
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,220,400.00	562,655,226.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(51,220,400.00)	(562,655,226.30)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
IX	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
X	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.12	(1,594,061,512.12)	-	5,257,365,068.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.12	(1,594,061,512.12)	-	5,257,365,068.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(21,760,524.99)	-	(21,760,524.99)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.12	(1,615,822,037.11)	-	5,235,604,543.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.12	(1,615,822,037.11)	-	5,235,604,543.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	4,254,907,090.24	-	4,254,907,090.24
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,849,976,358.38	1,450,222.12	2,639,085,053.13	-	9,490,511,633.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,361,406,100.00	9,745,704,878.81	615,701,221.19	94.1
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	10,029,406,100.00	9,426,159,534.81	603,246,565.19	94.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,256,300.00	892,264,533.58	107,991,766.42	89.2
Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	7,920,622,000.00	7,425,367,201.23	495,254,798.77	93.8
Үндсэн цалин	3,319,600,000.00	2,743,270,872.75	576,329,127.25	82.6
Нэмэгдэл цалин	2,419,200,000.00	2,400,795,438.73	18,404,561.27	99.2
Унаа хоолны нэмэгдэл	1,196,822,000.00	1,320,907,200.00	(124,085,200.00)	110.4
Урамшуулал	985,000,000.00	960,393,689.75	24,606,310.25	97.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,108,527,800.00	1,108,527,800.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	726,574,000.00	726,574,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	134,207,200.00	134,207,200.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	65,666,100.00	65,666,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	36,416,100.00	36,416,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	145,664,400.00	145,664,400.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,500,000.00	74,931,619.28	38,568,380.72	66.0
Гэрэл, цахилгаан	76,000,000.00	47,954,901.66	28,045,098.34	63.1
Түлш, халаалт	27,000,000.00	16,933,773.79	10,066,226.21	62.7
Цэвэр, бохир ус	10,500,000.00	10,042,943.83	457,056.17	95.7
Хангамж, бараа материалын зардал	68,896,300.00	60,510,102.00	8,386,198.00	87.8
Бичиг хэрэг	29,396,300.00	29,385,290.00	11,010.00	100.0
Тээвэр, шатахуун	20,000,000.00	15,000,000.00	5,000,000.00	75.0
Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,008,116.00	991,884.00	75.2
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	2,300,000.00	1,950,000.00	350,000.00	84.8
БҮТЭЗүйлс	13,200,000.00	11,166,696.00	2,033,304.00	84.6
Нормативт зардал	5,000,000.00	3,285,000.00	1,715,000.00	65.7
Эм,бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	3,285,000.00	1,715,000.00	65.7
Эд хогшил, урсгал засварын зардал	711,400,000.00	656,933,336.30	54,466,663.70	92.3
Багаж,техник хэрэгсэл	55,400,000.00	54,556,863.00	843,137.00	98.5
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	-	1,000,000.00	0.0
Урсгал засвар	655,000,000.00	602,376,473.30	52,623,526.70	92.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,460,000.00	96,604,476.00	4,855,524.00	95.2
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,320,000.00	61,765,635.00	3,554,365.00	94.6
Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	12,000,000.00	11,005,860.00	994,140.00	91.7
Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	230,500.00	69,500.00	76.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	66,000.00	74,000.00	47.1

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,100,000.00	6,075,000.00	25,000.00	99.6
Газрын төлбөр	600,000.00	461,481.00	138,519.00	76.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	332,000,000.00	319,545,344.00	12,454,656.00	96.3
Бусад урсгал шилжүүлэг	332,000,000.00	319,545,344.00	12,454,656.00	96.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	332,000,000.00	319,545,344.00	12,454,656.00	96.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,187,950.00	9,745,704,878.81	(9,732,516,928.81)	73,898.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,187,950.00	7,949,105.00	5,238,845.00	60.3
Төрийн өмч түрээслүүлсний орлого	13,187,950.00	7,912,770.00	5,275,180.00	60.0
Бусад орлого	-	36,335.00	-	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-	-	0.0
Улсын төсвөөс санхүүжих	10,361,406,100.00	9,737,755,773.81	(623,650,326.19)	94.0
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-	-	0.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	240	208	(32)	86.7
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	209	178	(31)	85.2
Үйлчлэх ажилтан	27	26	(1)	96.3
Гэрээт ажилтан	3	3	-	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,268,885.7 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,268,885.7 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, залруулагдаагүй 1 алдаанд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Улсын төсвөөс санхүүжилт олгосон шилжүүлэг 604,122.1 мянган төгрөг, орон нутгийн төсвийн Ерөнхий захирагчаас олгох татаас, санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг 5,275.2 мянган төгрөг нийт 609,397.3 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулгын тайланг бэлтгээгүй байна.	1	609,397.3	1	609,397.3	-	-	1	609,397.3	-	-	-	-
Тайлант онд нийт 11 ажилтны цалинтай чөлөөний хоногийг ажилласан хоногт оруулж тооцоолоогүй, цалинтай чөлөөний цалин хөлсийг амралтын цалингийн нийт дүнд оруулж тооцоолсны улмаас ээлжийн амралтын цалин хөлсийг 2,185.0 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон байна.	1	2,185.0	-	-	1	2,185.0	1	2,185.0	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Үндсэн хөрөнгө бараа материалын тодруулгад тайлагнасан шилжүүлэн авсан үндсэн хөрөнгө 889,999.5 мянган төгрөг нь санхүүгийн үр дүнгийн тайлангаас 17,215.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	17,215.8	-	-	1	17,215.8	1	17,215.8	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнагдсан үнэ төлбөргүй хүлээн авсан 40,175.2 мянган төгрөгийн орлогыг үндсэн хөрөнгө, бараа материалаар салган тусад нь тайлагнаагүй байна.	1	40,175.2	1	40,175.20	-	-	1	40,175.2	-	-	-	-
ҮХ-ийн тодруулгад тайлагнасан худалдан авсан 599,912.4 мянган төгрөгийн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй байна.	1	599,912.4	1	599,912.40	-	-	1	599,912.4	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланд ажиллагсдын тоог тайлагнаагүй байна.	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт 180,922.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 22 нэр төрлийн 51 ширхэг үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-	1	-
Дүн	7	1,268,885.7	4	1,249,484.9	2	19,400.8	6	1,268,885.7	1	-	1	-

3.2 Аудитаар нийт 2,314.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,314.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 7 иргэн байгууллагын дүнг 2,314.0 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	2,314.0	-	-	-	-	-	-	-	1	2,314.0	-	-
Дүн	1	2,314.0	-	-	-	-	-	-	-	1	2,314.0	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.